



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар Б/153

Хэрлэн сум

А.Баярбатыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.5 дахь заалт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн Б/536 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, хошууч Алтангэрэлийн Баярбат нь өөр ажилд томилогдох болсон тул 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын


дарга: Н.Хүрэлээ Цэргийн штабын дарга, Хурандаа

Гишүүд: Б.Дарханбаатар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Т.Баяртуяа Нярав

3.А.Баярбатын ажлыг Дайчилгааны офицер Л.Цэнддоржид зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Хүрэлээ)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА